

ГОВЬ-АЛТАЙ АЙМАН ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын Хантайшир Эрдэм сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/86/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
	Утас: 70483413      Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055      Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a>
	Аудитор      Ч.Даваасүрэн
	Утас: 99559722      Цахим хаяг: <a href="mailto:daavkach@gmail.com">daavkach@gmail.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	10
3.8 Аудитын гол асуудал.....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 101

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын Хантайшир Эрдэм сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын Хантайшир Эрдэм сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


**07020383**

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>89,039,509.07</b>	<b>96,158,382.95</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	88,937,424.07	96,158,382.95
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	43,464,713.31	43,464,713.31
35110	Тусгай зориулалттай материал	43,464,713.31	43,464,713.31
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	45,472,710.76	52,693,669.64
35410	Бичиг хэргийн материал	65,000.00	65,000.00
35420	Аж ахуйн материал	14,514,704.00	14,933,704.00
35460	Хүнсний материал	915,625.00	1,204,030.00
35470	Бусад хангамжийн материал	29,977,381.76	36,490,935.64
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,472,946,849.87</b>	<b>1,463,390,860.04</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,472,946,849.87	1,463,390,860.04
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,275,066,849.87	1,265,265,860.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,254,095,215.25	1,249,213,215.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	(98,119,740.16)	(143,756,463.12)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	7,800,000.00	7,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(7,800,000.00)	(7,800,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	216,551,997.85	127,312,705.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(165,342,681.58)	(43,597,875.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	102,818,116.27	86,640,319.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(49,261,130.85)	(24,871,114.53)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,325,073.10	14,325,073.10
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	197,880,000.00	198,125,000.00
39301	Програм хангамж	690,000.00	245,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	197,880,000.00	197,880,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,561,986,358.94</b>	<b>1,559,549,242.99</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,561,986,358.94</b>	<b>1,559,549,242.99</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,561,986,358.94	1,559,549,242.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,129,946,768.84	1,129,946,768.84
51101	Өмч: - төрийн	1,129,946,768.84	1,129,946,768.84
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	124,956,383.31	122,519,267.36
51210	Өмнөх үеийн үр дүн	5,321,233.86	124,956,383.31
51220	Тайлант үеийн үр дүн	119,635,149.45	(2,437,115.95)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	307,083,206.79	307,083,206.79
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,561,986,358.94</b>	<b>1,559,549,242.99</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,297,623,704.41	1,156,036,656.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	201,832,990.41	38,361,874.88
120	Нийтлэг татварын бус орлого	201,832,990.41	38,361,874.88
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	201,832,990.41	38,361,874.88
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	201,832,990.41	38,361,874.88
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		35,293,702.00
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		3,068,172.88
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,095,790,714.00	1,117,674,782.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	901,357,460.00	954,251,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	901,357,460.00	954,251,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,983,254.00	12,315,282.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,884,754.00	8,400,082.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,098,500.00	3,915,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	156,450,000.00	151,108,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	156,450,000.00	151,108,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,177,988,554.96	1,158,473,772.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,177,988,554.96	1,158,473,772.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,086,471,961.23	1,109,033,655.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	753,537,957.00	758,282,740.13
210101	Үндсэн цалин	688,052,567.00	705,145,202.13
210104	Урамшуулал	65,485,390.00	53,137,538.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,709,180.97	99,701,888.91
210201	Тэтгэврийн даатгал	67,007,452.01	70,605,698.34
210202	Тэтгэмжийн даатгал	4,615,602.33	7,169,332.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,156,290.72	5,807,947.18
210204	Ажилгүйдлийн даатгал	1,539,075.09	1,453,506.16
210205	Эрүүл мэндийн даатгал	15,390,760.82	14,665,404.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	124,757,281.72	138,607,608.00
210301	Гэрэл, цахилгаан	5,252,137.72	7,500,000.00
210302	Түлш, халаалт	108,414,504.00	126,308,000.00
210303	Цэвэр, бохир ус	11,090,640.00	4,799,608.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,538,475.79	8,871,414.27
210401	Бичиг хэрэг	1,435,000.00	1,483,600.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,299,910.00	2,980,895.27
210404	Ном, хэвлэл	40,000.00	167,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,689,200.00	939,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,460,000.00	2,430,500.00
210408	Бараа материал актальсны зардал	21,014,365.79	469,819.00
2105	Нормативт зардал	1,617,500.00	2,654,350.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	717,500.00	2,174,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	900,000.00	480,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,274,309.38	12,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	774,309.38	
210604	Урсгал засвар	9,500,000.00	12,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	151,200.00	-
210702	Дотоод албан томилолт	151,200.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,623,200.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	827,200.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,262,856.37	88,415,653.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,971,800.00	9,566,982.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	69,291,056.37	78,848,671.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,516,593.73	49,440,117.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,758,342.80	42,098,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,374,088.80	34,799,150.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,999,500.00	7,299,150.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,692,718.28	392.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,692,718.28	392.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,065,532.65	7,341,425.69
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,065,532.65	7,341,425.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	119,635,149.45	(2,437,115.95)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	119,635,149.45	(2,437,115.95)

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,129,946,768.84	307,083,206.79	124,956,383.31	0.00	1,561,986,358.94
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,129,946,768.84	307,083,206.79	124,956,383.31	0.00	1,561,986,358.94
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,129,946,768.84	307,083,206.79	124,956,383.31	0.00	1,561,986,358.94
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,129,946,768.84	307,083,206.79	124,956,383.31	0.00	1,561,986,358.94
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,129,946,768.84	307,083,206.79	124,956,383.31	0.00	1,561,986,358.94
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-2,437,115.95	0.00	-2,437,115.95
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,129,946,768.84	307,083,206.79	122,519,267.36	0.00	1,559,549,242.99

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,107,307,914.00</b>	<b>1,117,776,867.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>450,000.00</b>	<b>102,085.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	450,000.00	102,085.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	450,000.00	102,085.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	450,000.00	102,085.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,106,857,914.00</b>	<b>1,117,674,782.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	901,357,460.00	954,251,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	901,357,460.00	954,251,500.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	49,050,454.00	12,315,282.00
131104	дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,951,954.00	8,400,082.00
131105	төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд оги болсон нэмэлт орлого	4,098,500.00	3,915,200.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	156,450,000.00	151,108,000.00
132001	урсгал үйл ажиллагааны санхүүжилт торон нутгийн төсөвт байршувал	156,450,000.00	151,108,000.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,107,307,914.00</b>	<b>1,083,777,887.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,107,307,914.00</b>	<b>1,083,777,887.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,015,888,239.07</b>	<b>1,034,049,364.31</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	753,537,957.00	758,282,740.13
210101	Үндсэн цалин	688,052,567.00	705,145,202.13
210104	Урамшуулал	65,485,390.00	53,137,538.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	94,709,180.97	99,701,888.91
210201	Тэтгэврийн даатгал	71,623,054.65	70,605,698.34
210202	Тэтгэмжийн даатгал	-	7,169,332.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,156,291.10	5,807,947.18
210204	Ажилгүйдлийн даатгал	1,539,074.60	1,453,506.16
210205	Эрүүл мэндийн даатгал	15,390,760.62	14,665,404.51
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	124,757,281.72	138,607,608.00
210301	Гэрэл, цахилгаан	5,252,137.72	7,500,000.00
210302	Түлш, халаалт	108,414,504.00	126,308,000.00
210303	Цэвэр, бохир ус	11,090,640.00	4,799,608.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,589,110.00	8,787,495.27
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,500,000.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,299,910.00	2,980,895.27
210404	Ном, хэвлэл	40,000.00	167,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,689,200.00	939,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,460,000.00	2,800,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	1,617,500.00	2,654,350.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	717,500.00	2,174,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	900,000.00	480,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,674,309.38	12,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,174,309.38	
210604	Урсгал засвар	9,500,000.00	12,500,000.00
2107	<b>Томилот, зочны зардал</b>	151,200.00	
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,721,700.00	3,915,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ниитлэг ажил үйлчилгээний төлбөр	4,925,700.00	3,915,200.00
210806	хураамж Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,130,000.00	9,600,082.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,130,000.00	9,600,082.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>91,419,674.93</b>	<b>49,728,522.69</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	52,661,424.00	42,386,705.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,277,170.00	35,087,555.00
213208	хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан аюуан хаагчлал төлөөс үзүүлэх дэмжлэг	29,384,754.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,999,500.00	7,299,150.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	26,692,718.28	392.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,692,718.28	392.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	12,065,532.65	7,341,425.69
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,065,532.65	7,341,425.69
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	-	<b>33,998,980.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>33,998,980.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>33,998,980.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	33,998,980.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	33,998,980.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТИЙГ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	-	<b>(33,998,980.00)</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,105,359,500.00	1,098,119,767.31
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,105,359,500.00	1,098,119,767.31
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,062,971,500.00	1,055,733,062.31
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	762,554,300.00	758,282,740.13
210101	Үндсэн цалин	708,765,300.00	705,145,202.13
210104	Урамшуулал	53,789,000.00	53,137,538.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	102,455,000.00	99,701,888.91
210201	Тэтгэврийн даатгал	71,913,000.00	70,605,698.34
210202	Тэтгэмжийн даатгал	7,475,500.00	7,169,332.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,267,800.00	5,807,947.18
210204	Ажилгүйдлийн даатгал	1,528,700.00	1,453,506.16
210205	Эрүүл мэндийн даатгал	15,270,000.00	14,665,404.51
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	138,608,000.00	138,607,608.00
210301	Гэрэл, цахилгаан	7,500,000.00	7,500,000.00
210302	Түлш, халаалт	126,308,000.00	126,308,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,800,000.00	4,799,608.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,999,200.00	8,787,495.27
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,500,000.00
210402	Тээвэр, шатахуун	400,000.00	400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,099,200.00	2,980,895.27
210404	Ном, хэвлэл	200,000.00	167,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	939,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,800,000.00	2,800,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,655,000.00	2,654,350.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,175,000.00	2,174,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	480,000.00	480,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	44,500,000.00	44,498,980.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,000,000.00	16,999,000.00
210602	Тавилга	15,000,000.00	14,999,980.00
210604	Урсгал засвар	12,500,000.00	12,500,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,200,000.00	3,200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,200,000.00	3,200,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	42,388,000.00	42,386,705.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	42,388,000.00	42,386,705.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,088,000.00	35,087,555.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,300,000.00	7,299,150.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,105,359,500.00	1,098,017,682.31
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	954,251,500.00	946,910,074.31
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	954,251,500.00	946,910,074.31
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	151,108,000.00	151,107,608.00
132001	Орон нутгийн төсвөөс	151,108,000.00	151,107,608.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>49050454.00</b>	<b>12,315,282.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>49050454.00</b>	<b>12,315,282.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	19665700.00	12,315,282.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14400000.00	2,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,900,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	4,500,000.00	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4115700.00	3,915,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,115,700.00	3,915,200.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1150000.00	6,400,082.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,150,000.00	6,400,082.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	29384754.00	-
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	29384754.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,384,754.00	
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>49050454.00</b>	<b>12,315,282.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,951,954.00	8,400,082.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,098,500.00	3,915,200.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын Хантайшир Эрдэм сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын аудиторын туслах Ч.Даваасүрэн гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын Хантайшир Эрдэм сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Хүүхдийн өөрөө удирдлагатай сурах үйлийг дэмжих сурлагын чанар, хөгжил төлөвшлийг сайжруулан хоцрогдолгүй сургах, эрүүл аж төрөх амьдралын зөв хэв маяг, бие даан суралцах чадвар эзэмшүүлэхэд бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчин бүрдүүлж ажиллах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлийг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын Хантайшир Эрдэм сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлогын дүн 1,295.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 25.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 20.7 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын Хантайшир Эрдэм сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.15 хувиар буюу 2.9 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 96.1 сая төгрөг болж 7.2 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 67.9 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 3.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 62.9 сая төгрөгийн материалыг зарцуулж, аймгийн онцгой комиссын шийдвэрээр 0.8 сая төгрөг шилжүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,683.4 сая төгрөг болж 110.8 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 33.9 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 180.0 сая төгрөгийн хөрөнгө акталж 35.3 сая төгрөг дахин үнэлгээгээр орлого авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,559.5 сая төгрөг болж 2.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 10.9 хувиар буюу 141.6 сая төгрөгөөр буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 122.5 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,120.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 14.8 сая төгрөгөөр бууруулж, 1,105.4 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь хүүхдийн хоолны зардал (1500 төгрөг) болж өссөнтэй холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 5 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 1,105.4 сая төгрөгийн төсөв баталснаас 954.3 сая төгрөгийг улсын төсвөөс 151.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 954.3 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 151.1 сая төгрөг санхүүжилт авч нийт 1,105.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,098.1 сая төгрөгийг зарцуулж 7.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,098.1 сая төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 4.3 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 2.8 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 0.2 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Дээд шатны төсвийн захирагчаас 8.4 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 3.9 сая төгрөг нийт 12.3 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ.

Үүнээс багаж техник хэрэгслийн зардалд 2.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 3.9 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 6.4 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим системд 1,817.5 сая төгрөгийн 147 мэдээллийг ил тод байршуулахаас 1,817.5 сая төгрөгийн 147 мэдээллийг ил тод байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 0.9 сая төгрөгийн төлбөрийн акт, шилэн дансны хэрэгжилтийг хануулах албан шаардлага хүргүүлсэн. Аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан тухай албан бичиг ирүүлсэн

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн жилийн аудитаар

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийн чанар, ашиглалтын байдал
- Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
- Нягтлан бодох бүртгэлийн дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинж чанар, үнэнд дүн шинжилгээ хийх
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй

### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт ~~17.0~~ сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, ~~14.7~~ сая төгрөгийн зөрчил, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

#### 4.2 Төлбөрийн акт

- ✓ Ажилчдын үр дүнгийн урамшууллыг эрхлэгчийн тушаалаас 0.4 сая төгрөгөөр илүү , 1.9 сая төгрөг дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.3-т "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно", 4.7-т "Энэ журмын 4.3-т заасан нөхцөлийг хангасан багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг тухайн сургалтын байгууллагын эрхлэгч, захирал гаргана" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгллийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

#### 4.3 Албан шаардлага

- ✓ Цалингийн батлагдсан төсөвт хоолны зардал төлөвлөгдөөгүй байхад 12 сард хоолны хөнгөлөлт 11.1 сая төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь заалт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах" заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгллийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- ✓ Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр 3.1 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын 1.4 дэх заалт "ТБОНӨХ-өөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад авто машин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгллийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ
- ✓ Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь: Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын 1.1-д" Үндсэн үйл ажиллагаатай холбоотой , зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсвөөс , арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал, болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгллийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- ✓ Хөндлөнгийн мэдээлэлтэй тулган баталгаажуулахад 4.0 сая төгрөгийн түлш халаалтын өглөгтэй байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгллийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

- ✓ Татварын тодорхойлолтоорх цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй аудитлгах орлогоос суутгасан татварын 0.2 сая төгрөгийн авлага, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын 0.4 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

#### 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Есөнбулаг сумын Хантайшир Эрдэм сургууль	5	27.0	-	-	2	2.3	4	14.7		
Дүн		5	27.0	-	-	2	2.3	4	14.7		